- Салбар эмнэлгийн үйл ажиллагаанд Спортын гэмтлийн төвийг мэс заслын 20 ортой, сэргээн засахын 20 ортой тасгийг ажиллуулж, Arthrex Sunergy 4K дурангийн аппаратыг ашиглалтад оруулан 49 үйлчлүүлэгчид мэс засал хийж, сэргээн засах эмчилгээг 191 үйлчлүүлэгчид, амбулаториор 250 үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээ үзүүлсэн;
- Мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулж fortinet брэндийн fortiget firewall дотоод сүлжээнд суурилуулан, ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлсэн;
- Эмнэлгийн лабораторийн итгэмжлэлийн шаардлага MNS/ISO 15189 : 2008 стандартыг нэвтрүүлсэн;

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Хөдөлмөрийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Эрүүл мэндийн тухай хууль,
- Татварын тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Сангийн сайд, ЭМС-ын хамтарсан 2022 оны 49/118 дугаар тушаал “Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай”
- ЭМС-ын 2022 оны 216-р тушаал “Жагсаалт журам батлах тухай” /төлбөртэй тусламж үйлчилгээний журам шинэчлэх тухай

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөтэй гэж үнэлэв.

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Эрүүл мэндийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2023 онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,168,423.9 мянган төгрөгөөр буюу 19 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,859,832.1	146,114.4	(1,713,717.6)
Авлага	17,949,358.4	29,928,199.3	11,978,840.8
Бараа материал	3,214,041.5	4,552,134.5	1,338,092.9
Үндсэн хөрөнгө	37,772,610.9	40,337,818.7	2,565,207.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>60,795,843.0</b>	<b>74,964,266.9</b>	<b>14,168,423.9</b>
Өр төлбөр	-	9,052,172.1	(9,052,172.1)
Засгийн газрын хувь оролцоо	60,795,843.0	65,912,094.7	5,116,251.7
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/ өмчийн дүн</b>	<b>60,795,843.0</b>	<b>74,964,266.9</b>	<b>14,168,423.9</b>

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 146,114.4 мянган төгрөг болж, 1,713,717.6 мянган төгрөгөөр буурсан нь ЭМДС-аас олгох санхүүжилт бүрэн олгогдоогүйгээс эхний үлдэгдлээс зарцуулж 1,713,717.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Авлага дансны үлдэгдэл 11,978,840.8 мянган төгрөгөөр өссөн нь ЭМДС-аас авах тусламж үйлчилгээний авлага дутуу орж ирсэнтэй холбоотой. Дансны авлагын эцсийн үлдэгдэлд

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

29,796,056.7 мянган төгрөг, МББ Жаргалан ХХК-аас авах түрээсийн авлага 96,362.9 мянган төгрөг, эмнэлгийн байгууллагуудаас авах болон ажиллагсад илүү олгосон тэтгэмжийн авлага 35,779.5 мянган төгрөгийн авлага тус тус бүртгэлтэй байна.

Бараа материал төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 27,691,077.2 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 424,789.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, үйл ажиллагаандаа зарцуулсан 26,601,407.9 мянган төгрөг, акталсан 223,991.1 мянган төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Тус төвийн захирлын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/159 тоот тушаалаар ашиглалтын хугацаа дууссан 2022 онд бэлтгэсэн болон ЭМЯ-с 2023 онд үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 173,600.7 мянган төгрөгийн, агуулах усанд автсанаас ашиглах боломжгүй болсон 10,691.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг устгаж, данс бүртгэлээс хассан байна.

Үндсэн хөрөнгө худалдан авсан тоног төхөөрөмж 1,926,976.0 мянган төгрөг, ЭМЯ-аас шилжүүлэн авсан хөрөнгө 4,216,638.02 мянган төгрөг, үнэ шинэчлэн тогтоосон хөрөнгө 1,239,677.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2023 оны А/45 тогтоолоор балансаас балансад шилжүүлсэн 15,470.5 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2023 оны Т/394 тогтоолоор үнэ шинэчлэн тогтоосон элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө 2,479,354.8 мянган төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд ЭМДС-аас санхүүжилт бүрэн олгогдоогүйгээс бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудад өгөх 8,006,927.2 мянган төгрөг, нийгмийн даатгал болон татварт өгөх 1,045,244.9 мянган төгрөгийг өглөг тус тус бүртгэлтэй байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг ЭМДС-аас санхүүжих 59,913,068.2 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 3,129,023.0 мянган төгрөг, улсын төсвөөс 523,526.6 мянган төгрөг бүрдүүлэхээр, нийт орлого, зарлагыг 63,565,617.8 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг бууруулалгүйгээр 63,565,617.8 мянган төгрөгөөр баталсныг тодотголоор 6,898,186.0 мянган төгрөгөөр бууруулж, нийт орлого, зарлагыг 56,667,432.1 мянган төгрөгөөр баталсан боловч зарцуулаагүй үлдэгдэл 3,604,413.3 мянган төгрөг байгаа нь төсвийг бодитой төсөвлөөгөйтэй холбоотой.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхэд 53,049,886.3 мянган төгрөгийг ЭМДС-аас, үйл ажиллагааны орлогоос 6,731,187.4 мянган төгрөг, мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс 1,824,224.8 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр ЭМДС-аас 48,835,502.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлогоос 4,114,713.9 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна.

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 54,668,934.3 мянган төгрөг буюу 91 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг норматив зардал 2,869,415.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/			
	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	59,781,073.7	54,668,934.2	(5,112,139.5)	91.4
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	58,722,642.0	54,266,077.3	(4,456,564.7)	92.4
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	1,058,431.7	402,856.90	(655,574.8)	38.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тус төвд Олон нийтийг хамарсан осол гэмтэл, онц байдал, гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах зорилтын хүрээнд хэрэгжиж буй төслийг хэрэгжүүлэхэд 196,924.0 мянган төгрөг төсөвлөгдсөнөөс 142,986.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төслийн хүрээнд Үндэсний яаралтай тусламжийн багийн төлөвлөгөө, сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг эрүүл мэндийн салбарын болон бусад холбогдох байгууллагын мэргэжилтнүүдийг хамруулан зохион байгуулсан байна. ДЭМБ, Норвеги улсын мэргэжилтнүүдийн зохион байгуулсан сургалтад хамрагдаж, ширээний болон майхан эмнэлэг дэлгэж дадлага сургуулилт хийн, үндэсний яаралтай тусламжийн багийн үйл ажиллагаа, агаараар үйлчлүүлэгчийг тээвэрлэх, зөөвөрлөх зэрэг журмын төсөл дээр мэргэжлийн баг бүрдүүлж ажилласан бөгөөд олныг хамарсан осол гэмтэл, онц байдал, гамшгийн үед майхан эмнэлэг дэлгэн яаралтай мэс засал болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх сургуулилтыг хийсэн.

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авалтыг зохион байгуулахдаа нээлттэй тендер сонгон шалгаруулалтаар 21,310,104.4 мянган төгрөгийн 22, харьцуулалтын аргаар 424,316.5 мянган төгрөгийн 9, цахим дэлгүүрээс 4,381,647.00 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 4,445,246.37 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг шууд худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах салбар эмнэлэг нэмэгдсэнтэй холбоотой үндсэн хөрөнгийн бүртгэлийг стандарттай нийцүүлэх, эм эмнэлгийн хэрэгслийн орлого, зарлага болон хэвтэн эмчлүүлэгчдийн өвчтөний түүхийг бүртгэлд тавих хяналтыг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Авера аудит ХХК-ийн аудитор Ч.Баатархүү, аудиторын туслах Б.Цэндмаа, Х.Буянхишиг нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер М.Энхцэцэг, гүйцэтгэх захирал Г.Нарантуяа, дараагийн шатны чанарын хяналтыг Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Д.Болор-Эрдэнэ, аудитын менежер Ц.Хосжаргал, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Гэмтэл согог судлалын үндэсний төв 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлээ хуулийн хугацаа хоцроон ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 50,730,195.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 507,301.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 31,859,018.2 мянган төгрөгийн 1172 мэдээлэл оруулахаас 16,135,095.4 мянган төгрөгийн 506 гүйлгээ хугацаа хоцроож мэдээлсэн

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хоцроож байршуулсан зөрчлийг арилгаж, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.4 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.4.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын 2023 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг завсрын аудитад хамруулж, мөнгөн хөрөнгө, цалингийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данснуудад горим сорил хэрэгжүүлсэн.

Завсрын аудитаар 214.1 мянган төгрөгийн алдаа, 698,345.7 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, аудитын явцад 214.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 689,345.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг дахин хянахад зөрчлийг арилгасан байна.

##### 4.4.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилт 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	10,973.7	2	10,973.7	100.0
Албан шаардлага	2	28,356.5	2	28,356.5	100.0
Зөвлөмж	3	17,550.0	3	17,550.0	100.0
<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>56,880.2</b>	<b>7</b>	<b>56,880.2</b>	<b>100.0</b>

#### 4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох үйл ажиллагааг ЭМЯ-ны төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн №2/3968 албан тоотын дагуу 2021 оны 8 дугаар сарын 4-ний өдөр хурал зохион байгуулж, тус эмнэлгийн 3 албан хаагчийг гишүүнээр сонгон холбогдох материалыг ЭМЯ-д хүргүүлсэн боловч одоог хүртэл шийдвэрлээгүй байгаа асуудлыг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзэж байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 689,345.7 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад запруулсан.

Бараа материалын дэлгэрэнгүй тайлангийн үлдэгдлийг санхүүгийн тайлангийн үлдэгдэлтэй тулган шалгахад 689,345.7 мянган төгрөгийн бараа материалыг данс зөрүүлж зарлагдсаны улмаас зарим бараа материалын үлдэгдэл хасах тэмдэгтэй гарсан байсан. Энэ нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулгын 1.15-д "Санхүүгийн тайланд аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой," гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын толилуулга батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Аудитаар нийт 394,365.2 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 260.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 394,104.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1 зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлээ.

### 5.1 Төлбөрийн акт

Эмийн зардлын тооцоог насанд хүрэгсдийн мэс заслын тасгийн 3 дугаар сарын 296 өвчтөний түүхээс 35-г түүвэрлэн шалгахад 4 өвчтөний түүхэнд эмийн зардлыг 260.2 мянган төгрөгөөр илүү тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ЭМДС-с илүү авсан эмийн зардлын 260.2 мянган төгрөгийг улсын төсвийн дансанд төвлөрүүлэх.

### 5.2 Албан шаардлага

1. Ажиллагсад илүү олгосон 2,500.0 мянган төгрөгийн тэтгэмжийн авлагыг барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан Бодох Бүртгэлийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг барагдуулаагүй зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

2. Санхүүгийн тайланд толилуулсан нийт авлага, өр төлбөрийн дүнгээс 9,299.2 мянган төгрөгийн авлага, 382,305.7 мянган төгрөгийн өглөгийг харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," гэж заасантай нийцэхгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Шийдвэрлэсэн нь: Авлага, өглөгийн тооцоог баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

3. Тус байгууллага нь 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлээ хуулийн хугацаа хоцроон ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8-р зүйлийн 8.9.1.-д "... жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд ирүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх.

### 5.3 Зөвлөмж

#### Төлөөлөн удирдах зөвлөлтэй холбоотой асуудал

##### 1.1 Илрүүлэлт:


Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн №2/3968 дугаартай албан бичгийн дагуу 2021 оны 8 дугаар сарын 04-ний өдөр хурал зохион байгуулж, тус эмнэлгийн 3 албан хаагчийг гишүүнээр сонгон холбогдох материалыг ЭМЯ-д хүргүүлсэн боловч одоог хүртэл шийдвэрлээгүй байна. Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.7-д "Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл нь өмчлөгчийг төлөөлөх гурван гишүүн, тухайн эмнэлгийн хамт олныг төлөөлөх гурван гишүүн, олон нийтийг төлөөлөх гурван гишүүнтэй байна.", Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйл "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, түүнд тавих шаардлага"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

##### 1.2 Өгсөн зөвлөмж:

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хуульд заасны дагуу сонгож, ЭМЯ-ны шийдвэрлэхгүй байгаа асуудлын талаар дахин хандаж, шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.





Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан		Запруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бараа материалын дэлгэрэнгүй тайлангийн үлдэгдлийг санхүүгийн тайлангийн үлдэгдэлтэй тулган шалгахад бараа материалын зарлагыг данс зөрүүлснээс үлдэгдэл хасах тэмдэгтэй байна	1	689,345.7			1	689,345.7	1	689,345.7				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>689,345.7</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>689,345.7</b>	<b>1</b>	<b>689,345.7</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаал тны тоо	Тоо	Дүн
Эмийн зардлын тооцоог насанд хүрэгсдийн мэс заслын тасгийн 3 дугаар сарын 296 өвчтөний түүхээс 35-г түүвэрлэн үзэхэд 4 өвчтөний түүхийн эмийн зардал 260.2 мянган төгрөгөөр зардлыг илүү тайлагнасан байна.	1	260.2	1	260.2								

**Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Ажиллагсдад илүү олгосон 2,500.0 мянган төгрөгийн тэтгэмжийн авлагыг барагдуулаагүй байна.	1	2,500.0			1	2,500.0						
Санхүүгийн тайланд толилуулсан нийт авлага, өр төлбөрийн дүнгээс 9,299.2 мянган төгрөгийн авлага, 382,305.7 мянган төгрөгийн өглөгийг харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	391,604.9			1	391,604.9						
Тус байгууллага нь 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 01/179 албан бичгээр Авера аудит ХХК-д ирүүлсэн.	1	-							1	-		
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>394,365.2</b>	<b>1</b>	<b>260.2</b>	<b>2</b>	<b>394,104.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>						
Тус байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний нийт 31,859,018.2 мянган төгрөгийн мэдээлэл байршуулахаас 16,135,095.4 мянган төгрөгийн 506 зарлагын гүйлгээний мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	16,145,095.4	1	16,145,095.4		
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох үйл ажиллагааг ЭМЯ-ны төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 7 дугаар сарын 28-ний өдрийн №2/3968 албан тоотын дагуу 2021 оны 8 дугаар сарын 4-ний өдөр хурал зохион байгуулж, тус эмнэлгийн 3 албан хаагчийг гишүүнээр сонгон холбогдох материалыг ЭМЯ-д хүргүүлсэн боловч одоог хүртэл шийдвэрлээгүй байна.	1	-			1	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>16,145,095.4</b>	<b>1</b>	<b>16,145,095.4</b>	<b>1</b>	<b>-</b>





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2024 оны 09 сарын 02 өдөр /Date/ 2024.09.02  
Улаанбаатар хот /City/ Ulaanbaatar

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус эмнэлгийн насанд хүрэгсдийн мэс заслын тасгийн 3 дугаар сарын 4 өвчтөний түүхийг түүвэрлэн шалгахад эмийн зардлыг 260,246.00 (Хоёр зуун жаран мянга хоёр зуун дөчин зургаан) төгрөгөөр илүү тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.4-д үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна. Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалсагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, захирагч, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захирагчаны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5-д "бүртгэл, тооцол зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн," гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү тайлагнасан эмийн зардал 260,246.00 (хоёр зуун жаран мянга хоёр зуун дөчин зургаан) төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт газарт ирүүлэхийг Гүйцэтгэх захирал /Э.Галбадрах/, Санхүү бүртгэлийн албаны дарга /Ц.Энхбаяр/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АВЕРА АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Ц.ХОСЖАРГАЛ

Г.НАРАНТУЯА

0001090075



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 23 өдөр 68/АОИС0055  
СНАГ-2024/26 / ИА-СТА-743

Хуучирсан бичиг

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Гэмтэл согор судлалын үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд

Ажиллагсад илүү олгосон 2,500,000.00 (хоёр сая таван зуун мянган) төгрөгийн тэтгэмжийн авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэгээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтайд албан шаардлага өгнө". Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:


1. Авлагыг барагдуулаагүй зөрчлийг арилгах, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны дотор Үндэсний аудитын газарт зрүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Э.Балбадрах/, санхүү бүртгэлийн албаны дарга /Ц.Энхбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АВЕРА АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ

Ц.ХОСЖАРГАЛ

Б.НАРАНТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэн дүүрэг, 1-р саян, Бага тайруу-3, Үндэсний төвийн газрын 4 дүгээр байр,  
Утас: 31224100

Э-холбоо: [audit@audit.gov.mn](mailto:audit@audit.gov.mn), 31222133110 (10 х)

0001980204



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын эрэн 23 69/А0150055  
СНАГ-2024/26 /НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайланд толилуулсан нийт авлага, өр төлбөрийн дүнгээс 9,299,187.00 (есөн сая хоёр зуун ерэн өсөн мянга нэг зуун наян долоон мянган) төгрөгийн авлага 382,305,798.00 (гурван зуун наян хоёр сая гурван зуун таван мянга долоон зуун ерэн найман) төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эр зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өглөг, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Э.Галбадрах/, санхүү бүртгэлийн албаны дарга /Ц Энхбаяр/ нарт даалгав
- 3.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АВЕРА АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Ц.ХОСЖАРГАЛ

Г.НАРАНТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот /Чингэлтэй дүүрэг/, 1-р хороо, Бага тойруу-3  
Утас 21-264100

Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 21-264100

0001080206